

Нэг: ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Лүн сумын ЗДТГ] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Урьд гол,хоёр гардгын зам засварлах шороон даланг нэмэж засварлах ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг хаягаар ирүүлнэ:

/Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –д өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын\тоон гарын үсэг\ кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр / ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *[2020 оны 04 дугаар сарын 22 ны өдрийн]-ны өдрийн [09.30 цаг]¹-т нээнэ.*

Дотоодны давуу эрх тооцох эсэх:Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***[ЛҮН СУМЫН ТӨВИЙН 3 ДУГААР БАГИЙН ЗДТГ-ЫН
НЭГ ДАВХАР БАЙРНЫ 02 ТООТ ӨРӨӨ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА УТАС:99779963]***

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2019 оны] жилийн санхүүгийн тайлан Сүүлийн [2019] оны туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудын танилцуулга/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Замын инженер, техникийн ажилтнуудын судалгааны хүснэгт, ажилтан бүрийн танилцуулга 2.Инженер, техникийн ажилтнуудын / Диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбарласан хувь байна. <ul style="list-style-type: none"> -Замын инженер -Гагнуурчин -Хөдөлмөр хамгаалалын ажилтан -Туслах ажилтан
ТӨӨЗ 1.2	Санхүүжилтийн эх үүсвэрнь: <i>[Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 60.168.100 төгрөг]</i>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:2020 оны 04 дугаар сарын 22 ны өдөр</p> <p>Байгууллагын хаяг: [Лүн сумын төвийн 3 дугаар баг]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Лүн сумын төвийн 3 дугаар багийн ЗДТГ-ын нэг давхар байрны 02 тоот өрөө</p> <p>Огноо: [2020 оны 04 дугаар сарын 22 ны өдрийн]</p> <p>Цаг: [09 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ. 2.2	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:</p> <p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: <i>[Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –д өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын\тоон гарын үсэг\ кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ]</i></p>
ТӨӨЗ .2.3	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Лүн сумын төвийн 3 дугаар баг]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [Лүн сумын төвийн 3 дугаар багийн ЗДТГ-ын нэг давхар байрны 02 тоот өрөө]</p> <p>Огноо: [2020 оны 04 дугаар сарын 22 ны өдрийн]</p> <p>Цаг: [09 цаг 30 минут]</p>

<p>ТӨӨЗ .2.4</p>	<p>Гэрээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: [шаардлагатай]</p> <p>1.Хийн цохилтот нягтруулагч</p> <p>2. Ачааны авто машин</p> <p>3. Гагнуурын аппарат</p> <p>4.Зуурмагны хөнөг 0,75м3</p> <p>5. Зам гүүрийн засвар үйлчилгээ хийдэх нэн шаардлагатай багаж төхөөрөмжүүд</p> <p>Бусад нэмэлт шаардлагууд</p> <p>1.Ажлыг гүйцэтгэх шатны ажлын хуваарь, нарийвчилсан хугацааны график баталгаажуулан ирнэ.</p> <p>2.Тендерт оролцогч нь уг ажлыг санал болгосон үнийн саналд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг гарган ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ .2.5</p>	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: [шаардлагатай]</p> <p>Хэрэв барааг захиалагчид өөрийн байранд хүргэж өгөөгүй, хуваарийн дагуу нийлүүлээгүй,зам гүүрийг чанар муутай материалаар хийсэн,засварласан тохиолдолд гэрээний үүргээ зөрчсөнд тооцож “Хар жагсаалт”-д орох нөхцөл үүсэх болохыг анхаарах</p>
<p>ТӨӨЗ .2.6</p>	<p>Тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <p>1.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/тендер зарласнаас хойш тендер хүлээн авах хүртэлх хугацаанд нотариатаар баталгаажуулсан байх/</p> <p>2.Оролцогч компаний танилцуулга</p> <p>3.Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</p> <p>4.Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл</p> <p>7.Харъяалагдах банкуудын тодорхойлолт тендер зарласнаас хойш тендер хүлээн авах хүртэлх хугацаанд авсан байх</p> <p>8.Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкуудаас тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй талаархи мэдэгдэл ирүүлэх</p> <p>9.Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч буй эсэх тухай мэдэгдэл</p>
<p>ТӨӨЗ. 2.7</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий бүрдэнэ: [Урьд гол,хоёр гардгын замын засварын ажил ТӨАЛСЗДТГ/202001029]</p>
<p>Төсөвт өртөг</p>	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт:60.168.100 төгрөг</p>
<p>Төсөвт тооцож ирүүлэх зардал</p>	<p>Заавал тооцож ирүүлэх зардлын тооцоо:</p> <ul style="list-style-type: none"> • Захиалагчийн албан зардал- 601.681 төгрөг • Зураг төсөв зохиогчийн зардал-60.600 төгрөг

--	--

Зургаа :**ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Лун сумын Засаг дарга Б.Наранбат танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр: Хаяг:

Долоо: **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- | | |
|--------------------------------------|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |

- | | |
|---|---|
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн |

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

³ Алдангийг хэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан

**үед хийх
төлбөр**

материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм: ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Урьд гол,хоёр гардгийн замын засвар, шороон даланг нэмэж засварлах ажил ТӨАЛСЗДТГ/202001029]
ГЕН 2.1	Хийгдэх ажил нь: /Урьд гол,хоёр гардгийн замын засвар, 5 ширхэг голцоот гүүрийг шинээр хийх, замын шороон даланг нэмэгдүүлэх ажил/-аас бүрдэнэ. Ажлын талбай нь [Төв аймгийн Лүн сумын төвийн 1 дугаар баг]-д байрших
ГЕН 3.1	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр [2020.04.30] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [2020.06.15] ⁵
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа [1 жил] буюу 365 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,1]хувь байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [0,5] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2020.06.20]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [шаардлагатай]2020.06.20-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зураг,тайлан тооцоог хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ[0,5 хувь] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [шаардлагагүй]-иар тооцно.

⁴ Захиалагчтендерийнбаримтбичгийггараахаасөмнөгэрээнийтусгайнөхцөлийгбүрэнбөглөсөнбайна. Захиалагчийнгаргахуваарь, тайлангэрээнийтусгайнөхцөлдхавсаргана.

⁵ Ажлыгхэсэгчлэндуусгахаартөлөвлөсөнболэдгээрхугацаагжагсаана.

⁶ Ажлыгхэсэгхэсгээрдуусгахболонхэсэгбүрталдангхэрэглэхболэндтусгана.

АЖИЛН ТОО ХАМЖСОННР ХОНСАЛТ

№	Ажилны нэр	Нэгж	Цүнц хэмжээ
1	1-р сувицны бетон хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийх	м2	24.2
2	1-р сувицны зөвшүүлэх гурвал Ф4-бөмөрн тэмдэг бетон явдан эвсгөлт гэрлээ бүрдвэл	м	9
3	1-р сувицны тэмдэг бетон явдан суус үе хөдөлгөөн рөйш цуглааар тэгшлэх	м2	6.4
4	1-р сувицны тэмдэг бетон явдан суус хойрсонд 10см-н зурагтай дэвсгэр хийж хийх	м3	0.54
5	Тэмдэг бетон явдангийн гадаргуу, хөр тосон тусгагчар 2 үе хийж / Пойнтер	м	0.205
6	1-р сувицны ус зөвшүүлэх Ф400 мм-ийн тэмдэг бетон явдан үсрэн 2м-н урттай 4 ширхэг	м	0.025
7	1-р сувицны хуримтын хөдөлгөөн армат ургалж	тн	0.147
8	1-р сувицны 20см-н зурагтай дэвсгэр сувицны бетон хэвнээ хуримтын хөдөлгөөн / Бөмөрн тэмдэг М300	м3	5.12
9	1-р сувицны зөвшүүлэх явдан хөдөлгөөн сувицны дэвсгэр бетоноор хийгдсэн хэвнээ арматурлагч хийж	м3	4.4
10	1-р сувицны бетон хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м2	24.2
11	10см-н зурагтай дэвсгэр бетоноор 1-р далагчийн хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хийж	м3	3.12
12	1-р сувицны хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м3	18.2
13	1-р сувицны хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м3	12
14	1-р сувицны / 20см-н зурагтай хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж / Бульдозероор тэгшлэх, чөлөөтүүлэх	м2	120
15	1-р сувицны зөвшүүлэх гурвал Ф400мм-н тэмдэг бетон явдан хөдөлгөөн гадаргуу тусгаж	м	5
16	1-р сувицны тэмдэг бетон явдан суус үе хөдөлгөөн рөйш цуглааар тэгшлэх	м2	6.4
17	1-р сувицны тэмдэг бетон явдан суус хойрсонд 10см-н зурагтай дэвсгэр хийж хийх	м3	0.54
18	Тэмдэг бетон явдангийн гадаргуу, хөр тосон тусгагчар 2 үе хийж / Пойнтер	м	0.205
19	1-р сувицны ус зөвшүүлэх Ф400 мм-ийн тэмдэг бетон явдан үсрэн 2м-н урттай 4 ширхэг	м	0.025
20	1-р сувицны хуримтын хөдөлгөөн арматурлагч	тн	0.147
21	1-р сувицны 20см-н зурагтай дэвсгэр сувицны бетон хэвнээ хуримтын хөдөлгөөн / Бөмөрн тэмдэг М300	м3	5.12
22	1-р сувицны зөвшүүлэх явдан хөдөлгөөн сувицны дэвсгэр бетоноор хийгдсэн хэвнээ арматурлагч хийж	м3	4.4
23	1-р сувицны бетон хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м2	24.2
24	10см-н зурагтай дэвсгэр бетоноор 1-р далагчийн хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хийж	м3	3.12
25	1-р сувицны хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м3	18.2
26	1-р сувицны хэвнээс хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж	м3	12
27	1-р сувицны / 20см-н зурагтай хөдөлгөөн гадаргуу, ус тусгаарлагч хөр тосон тусгаж 2 үе хийж / Бульдозероор тэгшлэх, чөлөөтүүлэх	м2	90

Нүсрэн 1

АНГИЙН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАНСАЛТ

28	3-р сүлжээг ажиллуулах туухай Ф-400мм-н тэмдэг бетон явдан хоолойн тэвээр бүтээл	м	8
29	3-р сүлжээ тэмдэг бетон явдан суус ур доройд рэйлс цугламбар галцалт	м3	8.4
30	3-р сүлжээ тэмдэг бетон явдан суус хэргэц 10см-н зураан дахьгүйн дийрэг үеийг үеийг	м3	0.94
31	Төмөр бетон эргэнхэйг гадаргуу, нар тоосон төрөлгөөр 2 үе зэвэг /Грайндер	км	0.008
32	3-р сүлжээ ус замлуулж 8-200 мм-ийн тэмдэг бетон явдан урсах 12м-н урттай 8 ширхэг	мр	0.112
33	3-р сүлжээг хүчлэгтэй хамгаалж дамжуулах	т/м	0.187
34	3-р сүлжээ 200мм-н зураантай дахьгүйн сүлжээг бетон хоёр зочинтой хэргэц тэл /Төмөр бүтээл MS20	м3	4.8
35	3-р сүлжээг ажиллуулах явдан хоолойнтой сүлжээг дахьгүйн бетоноор хамгаалах рэйлс дамжуулахын цуглам	м3	6.8
36	1-р сүлжээг бетон хамгаалалтын гадаргууг ус тусгаарлагч дээр тоосон үүрэгтэй 2 үе зэвэг	м2	28.2
37	0.15м/бетон хамгаалалтын ажиллагааг ажиллагаагаар 1-р дахьгүйн дийрэг дээрх ажиллагаагаар хамгаалж өгөх	м3	112
38	3-р сүлжээг зөвхөн дахьгүйн 15см-н зураантай дахьгүйн дийрэг үеийг хүчлэгт зэвэг	м3	72
39	3-р сүлжээг зөвхөн дахьгүйн дийрэг дээр 10см-н зураантай хэргэц хүчлэгт зэвэг	м3	67
40	1-р сүлжээг /100мм-н зураан зөвхөн хэргэц дийрэг дийрэг үеийг булчирхайгаар тэвээж, хэргэцүүлж	м2	400

Цэг	Ажилын үндэс	Цэг	Таб. хэмжээ
1	1-р сүлжээ дахьгүйн хамгаалалтын ажиллагаагаар зөвхөн зөвхөнхэйг үеийг дийрэгт ажиллагаагаар өгөх	м3	258
2	Шархон дотор зөвхөн 10см-н зураантай дахьгүйн дийрэг үеийг хүчлэгт зэвэг	м3	378
3	Шархон дотор зөвхөн дийрэг дийрэг дээр 10см-н зураантай хэргэц хүчлэгт зэвэг	м3	108
4	Шархон дотор зөвхөн 100мм-н зураан зөвхөн хэргэц дийрэг дийрэг үеийг булчирхайгаар тэвээж, хэргэцүүлж	м2	1000

Ес: ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах

барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ___ дугаар сарын ___-ны өдөр эхэлж, _____ оны ___ дугаар сарын ___-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]